

**ЗҮҮНГАР УЛСЫН ДАВААЧ ХААНЫ ХОЁР ЖИЛИЙН ЗАСАГЛАЛ:  
СОРИЛТ, ТЭМЦЭЛ**

НАДМИДЫН СҮХБААТАР  
*МУБИС-ийн Түүхийн тэнхимийн дэд профессор*

**Агуулга:** Зүүнгар улсын зургаа дахь хаан Даваачийн уг гарал, хаан ширээнд суусан түүх, түүний дотоод, гадаадад явуулсан бодлогыг тодруулах замаар Зүүнгар улсын улс төр, нийгмийн хөгжлийн нэг зурвас үеийг судалсан болно. Даваачийн төр барьсан 1753-1755 он бол Зүүнгарын түүхнээ маш эгзэгтэй цаг мөч бөгөөд Зүүнгар улсад дотоодын эвдрэл дээд цэгтээ хүрч, отог, ангиуд гадагш дүрвэж бусдын эрхшээлд орж, Манж Чин улс цэргийн хүчээр Зүүнгар улсыг эзлэн авсан цаг үе мөн. Зүүнгар улс Манж Чин улсад эзлэгдэхэд юу нөлөөлсөн, үүнд Даваачийн улсыг удирдах ухаан дутагдсан уу? гадаад дотоод хүчин зүйлс юу бэ? гэх мэт асуудалд хариу өгөхөд чиглэсэн он, сар өдөр, оролцогчид, газар орон зэргийг нарийвчлан тодруулах замаар Даваачийн байр суурь, бодлого, түүхэн нөхцлүүд хэрхэн уялдсаныг судлав. Сүүлийн үед манж хэлний сурвалжууд судалгааны эргэлтэд орсон нь энэ сэдвээр судалгаа хийх, санал солилцох боломжийг нээж өгч байна.

**Түлхүүр үг:** Цэвээндоржнамжил, Галданцэрэн, Лхамдаржаа, Амарсанаа, Манж Чин улс, Хасаг, Хотон, отог, зайсан

**Keywords:** Tseveen Dorjnamjil; Galdan Tseren; Lkhamdarjaa; Amarsanaa; Manchu Qing dynasty; Kazakh; Khoton; otog; zaisan

ОРШИЛ

Зүүнгар улсын гурав дахь хаан Галданцэрэн (1727-1745)-ээс хойш тус улсад улс төр, нийгмийн гүн гүнзгий хямрал бий болсон тухай, дараачийн хаадын төр барих арга ухаан, туршлага дутуу, дотоодын ужиг хямрал болон гадаад хүчин зүйлээс хамаарч Зүүнгар улс доройтож мөхсөн гэсэн дүгнэлт гадаад, дотоодын судлаачдын бүтээлүүдэд нийтлэг байдаг. Дараачийн хаадын улс төр, эдийн засгийн бодлогыг хаан тус бүрээр нь нарийвчлан судлаагүй, чухам хэний үед ямар ололт амжилт, алдаа дутагдал улсыг мөхөөсөн тухай ялгаж салгаж бичихгүй иржээ.

Галданцэрэнгийн дараа түүний хөвүүд Цэвээндоржнамжил (1745-1750), Лхамдаржаа (1750-1753) нар Зүүнгарт засагласан ч харамсалтай нь хаан ширээний төлөөх тэмцэлд амь үрэгджээ. Галданцэрэнгийн бага хөвүүн Цэвээндаш бас амь үрэгджээ. Галданцэрэнгийн хөвүүд үхэж үрэгдээд хаан ширээнд суух хүн үлдсэнгүй. Харин түүний ойр төрлийн цорос тайж нараас Даваач нөлөөтэй, эрх сүртэй байсан учир хаан ширээнд суусан юм. Даваачийн засаглалын 2 жил гаруй хугацаанд түүнд ямар бэрхшээл, сорилт учирсан, түүнийг даван туулахаар улс төр, цэргийн ямар бодлого явуулсныг судлав.

## НЭГ. ДАВААЧИЙН УГСАА ГАРАЛ, НИЙГМИЙН БАЙДАЛ

Даваач бол Зүүнгар улсын их тайж нар болох Цорос угсааны 4 том язгууртнуудын нэгнийх нь төлөөлөл гэж ойлгож болно. XVII зууны эхэн хагаст Галданцэрэнгийн үед Зүүнгарын улс төрийн амьдралд нөлөө бүхий Галданцэрэнгээс гадна Их Цэрэндондов, Бага Цэрэндондов, Сэвдэн нарын хүчирхэг цэргийн жанжид, олон харьяатыг захирдаг нөлөө бүхий ноёд байв.

Тэдний дараагийн үеийнхэн гэвэл Лхамдаржаа, Даваач, Нэмэхжаргал, Жангарав, Галсандорж нар юм. Тэдний удам угсааны дараалал нь:

Хархул – Баатар хунтайж – Сэнгэ хунтайж – Цэвээнравдан – Галданцэрэн – **Лхамдаржаа**

Хархул – Баатар хунтайж – Бум – Их Цэрэндондов – Намжилдаш – **Даваач**

Хархул – Баатар хунтайж – Пунцагдаш – Бодьмөр – Сэвдэн – **Жангарав**

Хархул – Баатар хунтайж – Пунцагдаш – Намжилдорж – **Галсандорж**

Хархул - Мэргэн дайчин - Ахай – Гүнзан – Бага Цэрэндондов – Манж – **Нэмэхжаргал**

Эдгээр ноёдын дунд Зүүнгар улсын сүүлчийн цаг хугацаа тоологдож, улсын хувь заяа тэдний гарт байв.

Даваач нь Цоросын ихээхэн тайж бөгөөд өвөг эцэг Их Цэрэндондовоос харьяат ардыг нь өвлөн авчээ. Түүний эцэг Намжилдаш Их Цэрэндондовын ахмад хөвүүн. 1730-1733 онд Зүүнгар-Манжийн дайнд цэрэг удирдан оролцож явсан бөгөөд 1732 оны 5-р сард Намжилдаш, Хойдын Үйзэн хошууч (Амарсанаагийн эцэг) нар нэг түмэн цэрэг авч, Алгуйн газар Хасагийн газарт цэрэглэсэн бөгөөд түүний удирдсан цэрэг сэргийлэх, улмаар дарангуйлах үүрэгтэй байжээ<sup>1</sup>. Гэвч удалгүй Намжилдаш нас барсан байна.

Даваачийн өвөг эцэг Их Цэрэндондов нь цэргийн нэрт жанжин, түүхнээ “Бодлого хэцүү” хэмээн алдаршсан бөгөөд Цэвээнравдан хааны улс төрийн бодлогыг дэмжигч. Анх 1698 онд Цэвээнравдангийн зараалаар Галдан бошогтын яс, охин Зүнчихайг Данжилагийн гараас салган авч байснаар түүхнээ анх нэр

<sup>1</sup> На.Сүхбаатар. Цорос овгийн түүх. *Bibliotheca oiratica* – CVIII (108). УБ., 2021:169

гарна. 1716-1721 оны Төвдийг эзлэх дайныг удирдсан, 1731 оны зуны болсон Хотон нуурын дайнд ялалт байгуулж, Үүдэн цөл, Сүх алдах, Хэрээн чулуунд бага уулга тавиад, цэргээ хойш татан байлдсан цэргийн нэртэй жанжин юм. Их Цэрэндондов 1732 оны дайнаас хойш хүнд өвчилж байгаа 1735 онд нас баржээ. Түүний хөвүүд Намжилдаш, Дорждамба, Бали нар эцгээсээ өмнө тодруулбал 1732 оны сүүлчээр дайны шарх, өвчнөөр нас баржээ. Их Цэрэндондов харьяат ардаа тухайн үед амьд байсан дөрөвдүгээр хөвүүн Дашцэрэнд бус, Намжилдашийн хоёрдугаар хөвүүн Даваачид өгчээ<sup>2</sup>. Ийнхүү харьяат ард, нутаг өмчлөн авсан тэрбээр угийн авхаалж самбаагаа дайчлан нэрд гарсан байна.

Зүүнгарын хаан ширээнд дараалан суусан Цэвээндоржнамжил, Лхамдаржаа нар Даваачийг ихэд чухалд үзэн өөрийн хажууд байн байн дуудаж байв. Энэ нь Зүүнгарын нөлөө бүхий ноёны нэг байсантай холбоотой боловч, бас Галданцэрэнгийн гэрээслэлтэй холбож болохоор байна. Захины Мамутын харьяат Гэндэн хашиха Зүүнгарт туршуулаар илгээсэн тайж Дамиранд хэлэхдээ, *“Угтаа Галданцэрэн үхэх үед Даваачийг хүнийг захирч чадмуй, тайж тавьтугай хэмээн гэрээслэн өгүүлсэн билээ. Галданцэрэн үхсэн хойно олон зайсан нар энэ үгийг даган явсангүй басхүү Галданцэрэний хөвүүн Цэвээндоржнамжилыг тавив. Хожим бас Галданцэрэний гээсэн хөвүүн Ламдаржааг халан тавив. Даваачийг огт хэрэг шийтгүүлсэнгүй учирт Даваач машид хорсож сая тийнхүү дайн дэгдээсэн бөгөөд манай Өөлдийн хуулинд тайжийн төрлийн хүн аливаа хэн тайж сууваас болмуй. Даваач мөн манай тайжийн төрөл учир манай Зүүнгарын ард басхүү санаа дагамуй”*<sup>3</sup> гэжээ.

Хаан ширээнд суух Галданцэрэнгийн шууд удмын ноёдын уг тасарсан учир Цоросын тайж нарын нэг, тухайн үедээ эрх нөлөө бүхий Даваач хаан ширээнд суусан гэж үздэг өмнөх түүх бичлэгийг эргэн харах мэдээлэл дээрх баримтад хадгалагджээ. Даваачид Галданцэрэн итгэж хунтайж болох боломжтой гэж гэрээслэл үлдээсэн нь хожмын улс төрийн халуун тэмцлийн эх үүсвэрийг тавьсан байж болох юм.

## ХОЁР. ДАВААЧ ХААН ШИРЭЭНД СУУСАН НЬ

Галданцэрэн хааныг нас барсны дараа түүний гэрээслэлийн дагуу хоёрдугаар хөвүүн Цэвээндоржнамжил Зүүнгарын хаан ширээнд суусан билээ. Дараа нь түүний ах Лхамдаржаа хаан ширээнд суув. Тэдний явуулсан улс төрийн бодлого,

<sup>2</sup> Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин, хошой хэтэрхий баатар, чин ван, улсын эфү, сайд Цэрэн Зүүнгараас даган ирсэн Торгууд ястай, 37 настай, Эрхтэн отгийн зайсан Гомбожавын харьяат Мөнхөөс авсан өчиг /1736.08.08/. //Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-II (1734-1743). Манжаас орчуулсан Л.Энхсаруул. Bibliotheca oiratica – СХХV (125). УБ., 2024:117

<sup>3</sup> Сайд Зэрэн, Жаохуй, Үлдэн, Нусан, Ринчиндорж, Дэчинжав хичээнгүйлэн айлтгах нь /1754.05.08/ //Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III (1743-1755). Манжаас орчуулсан Л.Энхсаруул. Bibliotheca oiratica – СХХVI (12). УБ., 2024:213

гадаад харилцаа, тухайн үеийн Зүүнгарын нийгмийн хөгжлийн талаарх судалгааг өмнө нь тоймлон өгүүлсэн<sup>4</sup>.

Зүүнгарын хаан ширээнд 1750 оны 5-р сард суусан Лхамдаржаа 1751 оны зун Эрчист суусан Их Цэрэндондовын ач Даваачид зайсан Бохолдайг зарж, “улсын хэргийг зөвлөлдье” гэхэд, “Цэвээндоржнамжилыг барихад огт надад сонгосонгүй, намайг дуудах нь огт сайн санаа бус” гэжээ. Бохолдай хойш очоод, Даваач яасан ч бидэнд нөхөд болохгүй хэмээсэн учир Ламдаржаа зайсан Бохолдай, Өлзий нарт дайрах тушаал өгснийг Даваач лам Гэлэнгээс сонсжээ.

Түгшүүртэй мэдээг сонссон Даваач Алтайн Хав боржийн газарт суусан Дөрвөдийн ноён Даш, Цэрэн увш, Хойдын ноён Амарсанаа, Банжур, Цэрэн, Шагдар нарын хамт Чин улсад даган орохоор зөвлөлдөж, 1751 оны 9-р сарын 12-нд хөдлөхөөр болсон төлөвлөгөөг Дөрвөдийн ноёд Лхамдаржаад бичиг илгээн мэдэгджээ. Болзсон өдөр Цагаан хужир, Тарвагатайн газраас Даваач гарч 10-р сарын 8-нд Нарийн сайр газарт очсонд, Дөрвөдийн ноён Даш ойр тойрон байх газраас 5000 цэрэг цуглуулж Даваачийн 3000 хүнийг Хотон харгай ууланд хорьж, нэг дунд (тэн хагас-зох) хүнийг нь талжээ. Залган Шагдар цэрэг авч Даваачийг дарсанд Даваач, Амарсанаа нар 12 хүнийг авч Хасагийн зүгт зугатан гарчээ. Лхамдаржаагаас улмаар Зүүнгарын худалдааны бүлэгт байсан Даваачийн ардуудыг барих зарлиг буулгажээ. Өлзий, Бохолдай нарын 10 мянган цэрэг Нарийн бөөрөл гол, Алтай уулын хөвчийн Үхэр усны газарт Даваачийг тосжээ<sup>5</sup>.

Лхамдаржаа Хасагийн Абулайгаас Даваачийг нэхэмжилсэнд эс өгчээ. Лхамдаржаа 1751 оны 5-р сард 30 мянган цэрэг гаргаж Исык нуурт Хасагтай байлдаж Исум баатарыг алж, Бөх баатарыг амьдаар барьж, 15 мянга гаруй морийг булаав, 7-р сард тайж Галсандоржоор 15 мянган цэрэг удирдуулж Хасагаас сэргийлж Айхасун нухулд суулгав<sup>6</sup>.

1752 онд Лхамдаржаа тайж Сайнбэлэг, Нэмэхжаргалд 3000 цэрэг өгч Даваачийг авахаар Хасаг руу илгээсэн ч амжилт олсонгүй. Хожим Хасагийн хангууд Даваачийг байлгах дургүй болсон учраа Абулай Даваачид хэлжээ. Иймээс Даваач, Амарсанаагийн хамт уг аваачсан 73 цэргийг авч 11-р сард Хасагаас гарч, Амарсанаа болон түүний ах Балжирын Обид отгоос нийт 21 мянган цэрэг авч, Талхи даваанд нуугдаж өнгөрөн явах хүнийг хорьж, мэдээ нэвтрүүлэхгүй болгов. Лхамдаржаа зайсан Төрөх, Охит, Асир, Бодид цэрэг өгч

<sup>4</sup> Энэ тухай зохиогчийн бичсэн “Цэвээндоржнамжилын үеийн Зүүнгар улсын улс төр, нийгмийн хөгжил. //Acta historica. Tom XXV. Fasc 5. УБ., 2024, тал 58-72”.; “Лхамдаржаагийн үеийн Зүүнгар улсын улс төр, нийгмийн хөгжил. //Oiratica. Tom II. Fasc 6. УБ., 2024, тал 120-139” өгүүллээс үзнэ үү.

<sup>5</sup> Халхын урианхай зайсан Дутач Зүүнгарын урианхай зайсан Мажитайгаас сонссон зүйлсээ мэдүүлжээ. Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин, засгийн хошой чин ван, сайд Цэнгүнжав нарын айлтгал /1752.01.08/. //Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III. Bibliotheca oiratica-CXXVI (126). УБ., 2024:180

<sup>6</sup> 1752 оны 11-р сарын 17-ны өдөр Манжид дагасан Зүүнгарын зайсан асан Гэвсоломын хөвүүн Буянтын мэдүүлэг. //На.Сүхбаатар. Цорос овгийн түүх. Bibliotheca oiratica-CVIII (108). УБ., 2022:150

Даваачийг дайлуулан илгээжээ. Гэвч тэд Даваачид баригдаж, Төрөх, Охит нар дагаж, Бодь алагдав<sup>7</sup>.

Манжийн хилийн сайд нарын цуглуулсан мэдээллээс үзэхэд богино хугацаанд цэргийн хүчийг олсон Даваач, Амарсанаа нар 11-р сарын 27-ны үүрийн хярд гэнэт Лхамдаржаагийн нутагт ирж түүнийг хороож 12-р сарын 14-нд Даваач хааны ширээнд суужээ. Ийнхүү Даваач билгийн улирлын өвлийн сүүл сарын 14 буюу 1753 оны 1-р сард Зүүнгарын хаан ширээнд суужээ.

Даваач 1753-1755 онд 2 жил гаруй Зүүнгарын хаан ширээнд суусан, Зүүнгар улсын сүүлчийн хаан юм. Даваачийн хаан ор суух санаатайг өмнөх Цэвээндоржнамжил, Лхамдаржаа нар мэдэж, сэрдэж, болгоомжилж байжээ. Тухайлбал, Цэвээндоржнамжил түүний хүүг барьцаанд байлгаж байв. Лхамдаржаа “Даваачийн хүн олон, газар бэрх хэмээн санаж, мөн аймшиггүй дарахаар одсонгүй”<sup>8</sup> гэж Манжид дагасан Дашдаваагийн зайсан Саарал мэдүүлж байв.

### ГУРАВ. ДАВААЧИЙН ЭСРЭГ ГАРСАН БОСЛОГО ТЭМЦЛҮҮД

Даваач хаан ширээнд суусныг Цоросын болон худ ургийн холбоо хамааралтай Хойдын олон тайж нар эсэргүүцэв. Үүнд;

#### ***Цоросын Нэмэхжаргал нарын эсэргүүцэл:***

Энэ үйл явдал Даваачийн хаан сууринд сууснаас хэдхэн сарын дараа буюу 1753 оны зун болсон хэрэг. Гол эсэргүүцэгч нь Бага Цэрэндондовын ач Нэмэхжаргал бөгөөд өөрийн дүү нартай холбоолжээ. Бас Лхамдаржаагийн зайсангууд Нэмэхжаргалыг хүрээлж өшөөг авсугай хэмээн гал дээр тос нэмснээр эхний томоохон бослого гарав. Тэд цэргийн хүчээр Даваачийн өргөөг довтолж зугатуулжээ. Даваачийн эсрэг Дөрвөдийн ноёдыг татан оролцуулахыг санаачилсан нь Дөрвөд аймгийн цаашдын хувь заяа, байр байдалд хүнд хохирол үзүүлсэн байна.

Удалгүй Даваач хүчийг хуримтлуулан Шагдарманж, Галсандорж нарт цэрэг өгч Нэмэхжаргалыг хороож, Ирид очиж дахин сууринд суусан байна<sup>9</sup>.

#### ***Дөрвөдийн ноёдын эсэргүүцэл, дүрвэлт:***

“Дөрвөн ойрадын намтар оршвой” хэмээх тод үсгийн түүх-д “Амарсанаа, Даваач хоёр нарийн учир Дөрвөд Даш ноён сонсоод Салбадоржийг явуулж зар

<sup>7</sup> Бичгийн эрхэн сайд, хиа захирагч дотоод сайд шударга баатар гүн сайд Фүхэний айлтгал. /1754.02.07/. //Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III. Bibliotheca oiratica-CXXXVI (126). УБ., 2024:206

<sup>8</sup> Хөхнуур, Фаньзы нарын хэргийг шийтгэх мэйрэний зангийн зэрэг Бандийн айлтгал. ///Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III. Bibliotheca oiratica-CXXXVI (126). УБ., 2024:160-164

<sup>9</sup> 1754 оны 2-р сарын 23-ны өдөр, Юйбаагийн айлтгал. Захчины зайсан Хөгшин Мамудаас авсан мэдүүлэг. // Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III. Bibliotheca oiratica-CXXXVI (126). УБ., 2024:208

*тархаав. ... Хаан [Даваач], Даш ноёныг зээ цуглана гэж оров. Даш ноён ирэв, өшөөрхөж Даш ноёныг нь хороов. Дөрвөд бас хийд олов. Хаан ширээ сэлшгүй болов. Амарсанаа ширээ булаалдан дайн болов. Хаанаас цэрэг морд хэмээн зар ирэв. Дөрвөд чуулган чуулав. Зарим нь цэрэг мордоё гэв. Баяд ноён Абу зарлиг болов, энэ ер талаар, манжийн хаанд ороё гэв. Бүгдээр зөв гээд өдөр шөнөгүй нүүв”<sup>10</sup>* гэсэн мэдээ бий. Даш ноён Лхамдаржаагийн эсрэг тэмцэж байсан Амарсанаа, Даваач нарын нууцыг задалж Лхамдаржаад мэдэгдсэн, Даваач, Нэмэхжаргал нар тэмцэлдэж байхад дөрвөдүүд Нэмэхжаргалыг дэмжсэн явдал, Даваач хаанаас Дөрвөдөөс цэрэг татах гэсэн зэрэг нөхцөл байдал Дөрвөдүүд Манжид дагах шалтгаан болов. Үүнээс гадна Даш ноёныг Даваач өргөөндөө дуудаж ирүүлээд хороосон явдал гурван Цэрэнийг Манжид орох гол шалтгаан болжээ.

1753 оны 9-р сарын 21-нд 56 настай Дөрвөдийн тайж Цэрэн, 26 настай Цэрэн увш нар харьяат 3000 өрхийг авч Эрчис голоос Чин улсын зүг хөдлөв<sup>11</sup>.

### ***Цэвээнравданы зээ нарын хаан ширээний төлөөх тэмцэл:***

Нэмэхжаргалын дараа Даваачтай хаан ширээ булаалдсан хүмүүс бол Цэвээнравданы зээ нар байлаа. Хойдын Сайнбилигийн дүү Данжинванбугийн дөрвөн хөвүүн Абгэлэг, Абраг, Эсгэх, Чойдаш нар өөрсдийгөө Цэвээнравдан хааны жинхэнэ зээ, Даваач нагацын сууринд суувал болохгүй хэмээн цэрэг цуглуулж Даваачтай байлдахаар бэлджээ. Үүнийг сонссон Амарсанаа арга үүсгэж, Хойдын ноёдод хэлэхдээ, “Даваачийг дайран одно, та араас туслан ир” гэж бичиг илгээж, нөгөө талаар Даваачид мэдээ өгч Талхи голын Цухал газарт болзож хоосон буу тавьж хуурмаглан нэг удаа Даваачтай байлджээ. 1753 оны 10-р сард тайж Авгэлэг нарын цэрэг Амарсанаагийн заавар ёсоор ирсэнд, Даваач Амарсанаа хоёр талаас хавчин нэг зэрэг байлдаж хороожээ<sup>12</sup>.

### ***Даваачийн эсрэг Амарсанаагийн тэмцэл:***

Даваач анх Ламдаржааг унагаах үед Амарсанаа Хасагийн цэргийг авч Обидын зэрэг таван отгийг уулгалахад олны санаа Амарсанаа Хасагийн цэргийг авч Зүүнгарыг уулгалжээ хэмээн буруушаасан учир Даваач Амарсанааг муугаар үзэх болжээ<sup>13</sup>. Үүний дараа Нэмэхжаргал, Хойдын ноёдын тэмцлийг дарахад Даваачид тусласан Амарсанаа давуу эрхтэй болж, улмаар Алтайн булга барих урианхай ардыг хүсэмжилж, түүний хүсэлтээс татгалзсан учир тэр хоёр муудсан

<sup>10</sup> “Дөрвөн ойрадын намтар оривой” 10 v – 11 r. //Bibliotheca oiratica - LX (60). УБ., 2016:110

<sup>11</sup> 1753 оны 11-р сарын 15-ны өдөр, Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин, засгийн хошой чин ван сайд Цэнгүнжавын айлтгал. Дөрвөдийн тайж Цэрэн, Цэрэн увш нарын илгээсэн Баянхишиг, Дутурган нарын мэдүүлэг. // Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III. Bibliotheca oiratica-CXXVI (126). УБ., 2024:192-195

<sup>12</sup> 1753 оны 12-р сарын 23-ны өдөр, Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин, засгийн хошой чин ван сайд Цэнгүнжавын айлтгал. Урианхайн зайсан Дутач Зүүнгарын урианхайгаас олсон мэдээллийг айлтгав. // Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III. Bibliotheca oiratica-CXXVI (126). УБ., 2024:203-204

<sup>13</sup> 1754 он, Захчины зайсан Хөгшин Мамутаас авсан мэдүүлэг. // Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III. Bibliotheca oiratica-CXXVI (126). УБ., 2024:208

тухай Илид очсон урианхай зайсан Божох, дэмч Дэнжилай нарт Даваач хэлжээ. Ингээд Амарсанааг барихын тул Даваачаас Галсандоржид 10 мянган цэрэг, Жанагаравт 5 мянган цэрэг өгч илгээсэнд Амарсанаа Нарийн буруулд орсон учир хядаж чадсангүй. Иймд Алтайд суусан урианхай нарыг цэрэг авч Хад уулын амыг хамгаалахыг тушаав. Нарийн буруул газар маш бэрх цухал, үлэмж цэрэг орвол болохгүй учир Амарсанаа Даваачийг хүчлэн тэмцэв. Даваач Амарсанаа хоёр багаас амраг элэгсэгээр ханилж, харилцан туслан явсан бөгөөд одоо яагаад муудсаныг Зүүнгарын ард гайхан хэлэлцэж байжээ<sup>14</sup>.

Амарсанаа хэлэхдээ, Ламдаржаа дүү Мөгүшийг хаан суулгасангүй учир олны санаа дагасангүй. Дашдавааг Хотонгийн газраас суллаж миний хамт хоёр гар болгож чамд туслан Галданцэрэний үе адил жарган амьдарсугай хэмээхэд Даваач намайг сэжиглэв. Алтай ойр сууж амьдрахад тус болгож гөрөөчилсүгэй хэмээхэд Манжид дагах санаатай хэмээн цэрэг илгээхэд харилцан муудав<sup>15</sup> гэсэн байдаг.

Амарсанаа, Даваач нар нийт 7 удаа байлджээ. 1753 оны өвөл Зүүнгарын умард хилийн ард иргэд Хасагт, дээд талын хилийн ард иргэд Амарсанаад уулгалагдав. Энэ үед Амарсанаа ах Банжурыг Хасагт илгээж цэргийн тусламж хүсчээ. 1754 оны 3-р сарын 28-нд Даваач Амарсанааг дайрахаар цэрэг илгээв. Амарсанааг дайрахад морь мал олдоогүй учир хотонгууд, лам нараас авчээ. Даваач Эрчист ирж тайж Норов, Жанагаравт 5000 цэрэг өгч Алтайн Хүрээт давааг давж Ховд голын эх Хотон, Хурган нуураар Гурван зайр, Хад уулын газарт сэргийлэн илгээв<sup>16</sup>.

Цэгээн нуурт суусан Захчины Хөгшин Мамутад Даваач хаан Хулгайч хэмээх хүнийг илгээж тамга дарсан бичигт, “чи хуучин хүн, миний өшөөтэй дайсан цөм дуусав. Одоо Амарсанаагаас гадна миний зүг эсэргүүцэлдэх хүн үгүй. Захчинаас 400 цэрэг, Буучнаас 600 цэрэг, урианхайгаас 1000 цэрэг авч Хад уул амыг тос. Жанагарав, буруд Ням 1000 цэрэг авч Хандгайтаас Дөрвөлжинд оч, Баяр ноён цэрэг авч Цагаан овоог тос, Даваач би Эрчис голыг хариуцна. Амарсанааг барих цагт дөрвөн анги болж орвол Амарсанаа тэнгэрт нисэхгүй, модны дотор загаслахгүй, баригдах нь ойлгомжтой” гэж 4-р сарын 22-нд цэрэг орохоор болжээ<sup>17</sup>.

<sup>14</sup> 1754 оны 3-р сарын 23-ны өдөр, Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин, засгийн хошой чин ван сайд Цэнгүнжав нарын айлтгал. Бэйс Пунцаг, гүн Дамбай нарын урианхайн ард Зүүнгарын урианхайн зайсан Мажидай, дэмч Дэнжилай нараас олсон мэдээллээ айлтгав. // *Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III*. Bibliotheca oiratica-CXXXVI (126). УБ., 2024:209-212

<sup>15</sup> Амарсанааг байцаасан сайд Зэрэн, Шүхэдэ, Цэнгүнжав, Ринчиндорж нарын айлтгал. // *Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III*. Bibliotheca oiratica-CXXXVI (126). УБ., 2024:234-237

<sup>16</sup> 1754 оны 6-р сарын 7-ны өдөр, эфү Цэрэний айлтгал. Зүүнгарын Хошуудын тайж Лувсандаржаагийн харьяат Балсаны мэдүүлэг. // *Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III*. Bibliotheca oiratica-CXXXVI (126). УБ., 2024:218-220

<sup>17</sup> 1754 оны 7-р сарын 9-ний өдөр, эфү Цэрэний айлтгал. Захчины зайсан Хөгшин Мамудын харьяат Хожярын даган орохдоо өгсөн мэдүүлэг. // *Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III*. Bibliotheca oiratica-CXXXVI (126). УБ., 2024:224-225

15 мянган цэргийг тайж Шагдарманжаар удирдуулж, тайж Хотон охин, зайсан Өлзий хоёрыг дагалдуулж 30 мянган цэрэг өгч гурван замаар Эрчисээр давшиж Амарсанааг дайлахад Амарсанаа цэрэг авч угтан байлдав. Энэ үед урианхайд алба зарсан Тарвай зайсан 3000 цэрэг авч 1754 оны илүү 4-р сарын сүүлээр мордож<sup>18</sup>, Даваачийн зарсан тайж Норовтой нийлж 10 мянган цэргээр Цагаан даагын газарт байх Амарсанаа, Нэмэхийн адууг олзолжээ. Амарсанаа Норов нартай нэг өдөр нэг шөнө байлдаж тал ардаа авч Болболжих ууланд оржээ. Урианхай зайсан Мажидай уулгалж авсан Амарсанаагийн хүнийг урианхай газарт авчирч тархаажээ<sup>19</sup>. Шагдарманж цэрэг авч Амарсанаа, Нэмэх нарын Дулаан хард байх нутгийг 5-р сарын 8, 9-нд дарж уулгалав. Амарсанаа 1000 гаруй хүнийг авч Эрчисийн Хойтон хошуунд иржээ<sup>20</sup>.

Болсон өдөр Даваач Бор хужирт сууж, цэргээ Цэрэн ноёнд өгч илгээв, Амарсанаа Цэрэн ноёнттой байлдахад Даваач, Баяр ноён хойш буруулжээ. Даваачийн хоёр ангийн цэрэг Амарсанаад дарагдаж, Цэрэн ноёныг барьсны дараа Норов ноёнд хэлсэн нь, би Даваачийн Баяр ноёныг дарав, чи надад дага, итгэхгүй бол би Даваачийн Цэрэн ноёныг барьж алав хэмээсэнд Норов ноён хүн илгээж үзвэл үнэн учир Норов ноён Амарсанаатай байлдаж Барга нуурын дээд талыг сахижээ. Хөгшин Мамуд Төөрүүл ширэгт Амарсанаагийн ардыг уулгалсаны дараагийн өдөр Амарсанаа Бархай нуурын өмнөд ууланд нэхэн ирж байлдахад хоёр өдөр байлдаж Амарсанаа дутаав. Мамуд 400 цэрэг авч Амарсанаагийн 1000 гаруй өрх, тэмээ морь үхэр хонь 25 мянга уулгаж авч ирсний дараа Амарсанаа гэнэт ирж Захчины 150 өрхийг уулгалж, 1754 оны 7-р сарын 3-нд Хотон овоог өнгөрч, Манж Чин улсын хилийн зүг оджээ<sup>21</sup>.

#### ***Хойдын Бадамцэрэнгийн тэмцэл:***

Амарсанаагийн ах Бадамцэрэн Хасагаас цэрэг авч ирж Даваачийн эсрэг дайтаж байжээ. Бадамцэрэн 1754 оны өвлийн туршид Даваачтай байлдсаар байж. Даваач цэргийн ихээхэн хүч хуримтлуулан Хойдын Бадамцэрэнтэй тулалджээ. 1755 оны 2-р сарын сүүлчээр Манжийн хоёр замын цэрэг орох үед Даваач Бадамцэрэний эсрэг дайтаж завгүй байжээ.

<sup>18</sup> 1754 оны 5-р сарын 28-ны өдөр эфү Цэрэний айлтгал. Зүүнгарын урианхай зайсан Мангалхагийн харьяат Энхжиг, Мамуд нараас авсан мэдүүлэг. // *Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III*. Bibliotheca oiratica-CXXVI (126). УБ., 2024:218-220

<sup>19</sup> 1754 оны 7-р сарын 1-ний өдөр, эфү Цэрэний айлтгал. Зүүнгарын урианхай зайсан Мажидай, Мангалхагийн сонссон мэдээ. // *Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III*. Bibliotheca oiratica-CXXVI (126). УБ., 2024:220-221

<sup>20</sup> 1754 оны 5-р сарын 30-ны өдөр эфү Цэрэний айлтгал, Захчины зайсан Хөгшин Мамудын үг. // *Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III*. Bibliotheca oiratica-CXXVI (126). УБ., 2024:226-227

<sup>21</sup> 1754 оны 7-р сарын 9-ний өдөр, эфү Цэрэний айлтгал. Захчины зайсан Хөгшин Мамудын харьяат Хүжжар даган орохдоо өгсөн мэдүүлэг. // *Зүүнгар улсыг тагнасан Манжийн хилийн сайдуудын айлтгал-III*. Bibliotheca oiratica-CXXVI (126). УБ., 2024:224-225

## ДӨРӨВ. ДАВААЧ ОЛЗЛОГДОЖ ЗҮҮНГАР УЛС МӨХСӨН НЬ

Даваач, Амарсанаа нар анх Лхамдаржаагийн эсрэг бослого гаргахдаа Зүүнгар улсыг хуваан, ээлжлэн захирах тохиролцоо хийсэн гэж олонх судлаачид үздэг. 1753 оны билгийн улирлын өвлийн сүүл сард Амарсанаа Хасагийн дэмжлэгтэйгээр Даваачийг довтолж, Даваач ялагдан Борталд иржээ. Амарсанаа Дөрвөдийн суларсан нутаг Эрчист ирэхэд Даваач ихээхэн цэрэг хуралдуулан сөрөг довтолгоог эхлүүлсэн байна. Үүнээс зугатан Амарсанаа нар 1754 оны билгийн улирлын 7-р сард Манжид дагаар оржээ. Харагчин тахиа (1753) жилийн өвлийн сүүл сар буюу 1754 оны 1-р сараас Хөх нохой жилийн намрын эхэн сар буюу 1754 оны 8-р сар хүртэл 7 сар өрнөсөн Даваач-Амарсанаа нарын тэмцэл Зүүнгар улсыг туйлдуулан хоосруулжээ.

Галданцэрэн хааны 3 хөвүүн удаа дараагаар амиа алдаж, хааны ор суух хүнгүй болсон үед Зүүнгар улсын хаан ширээний төлөө Цорос угсааны хамгийн их эрх мэдэлтэй, ихээхэн тайж Их Цэрэндондов, Бага Цэрэндондов нарын ач Даваач, Нэмэхжаргал нар анхлан тэмцэлдэв. Дараагаар Цэвээнравданы зээ нараас хаан ширээний төлөө бослого өрнүүлж Зүүнгар улсыг дотоодын иргэний дайны хэмжээнд аваачсан юм. Хардлагаас зугатаах, амь насаа хамгаалах зэрэг бодол өвөрлөсөн зарим аймгууд Манж Чин улсын зүг тэмцэв. Дөрвөдийн гурван Цэрэний 3000 гаруй өрхийн 17000 ам хүн, Амарсанаа, Нэмэх нарын 4000 өрхийн 20000 гаруй ам хүн Манжид дагаар оржээ. Зах хязгаарын Захчин, Урианхай нарын отгууд Манжийн нөлөөлөлд орсноор Зүүнгар руу довтлох Манжийн цэргийн зам чөлөөрсөн байна.

Зүүнгар улсын дотоодын тэмцэл гаарч, иргэний дайнд автагдаж олон аймгууд өөрт нь дагаар орж буйг ашиглан Чин улс хэдэн арван жилийн туршид эзлэн авахыг санаархаж байсан зорилгоо биелүүлэх боломж хэмээн тооцож 1754 оны билгийн улирлын 5-р сард Зүүнгарын эзлэн авах дайн хийхээр шийдвэр гарган 1 жил бэлдсэний дараа 1755 онд цэрэг оруулахаар болжээ.

Чин улс баруун (Бархөл), умард (Алтай) гэсэн 2 замаар үлэмжхэн хэмжээний цэргийг 1755 оны билгийн улирлын 2-р сард давшуулжээ. Гэтэл Даваач энэ үед цаад талдаа Хасаг болон Хойдын Бадамцэрэн тайжтай байлдаж, урагшилж ухарч явжээ. Манжийн цэрэг Зүүнгарын ард иргэдэд ухуулах ба дайлан дагуулах аргыг зэрэг хэрэглэн давшсаар нутгийн гүнд оржээ. Хоёр замын цэрэг билгийн улирлын 4-р сард Борталд нийлж цааш давшжээ. Манжийн цэрэг нэгэнт нутгийн гүнд орж ирсэн үед гэнэт ухаан орсон Даваач Гэдэн уулын газар түм шахам цэрэгтэй хүлээж хоригложээ. Гэвч Манжийн тал шөнийн цагаар гэнэдүүлэн дайрч Даваачийг зугатуулжээ.

1755 оны 6-р сарын 24-нд Турманы бек Хожис Даваачийг олзлон Умард дахиныг тогтоогч жанжин Бандийн цэргийн хүрээнд хүргэж өгсөнөөр Зүүнгар улс Манжид эзлэгдэв. Манжийн Тэнгэрийн тэтгэсэн хаан “Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг” хэмээх 172 дэвтэр төрийн албан түүхийн оршилд “... *Соёлыг дэлхий дахинд дэлгэрүүлж, Алтай уулыг дотоод газрын зураг*

дансанд оруулж, хоёр түмэн газрын чинад дахь ардаас дараалан хаши барих албыг өргөн барьж ирэв. Хорин найман гэрийн одны тусгалаар гадаад хүртэлх хил хязгаарыг ихэд тэлэв...”<sup>22</sup> хэмээн баяр бахдалтайгаар бичсэн буй.

Даваач хаан цагийн байдалд тохируулсан бодлого явуулж чадсангүй, ахар богино бодол, ойр зуур сэтгэсээр Дундад болон Төв азийн улс төрийн гол тоглогч Зүүнгар улсыг Манжид эзлэгдэх нөхцлийг бүрдүүлж өгсөн юм. Өөрийн угсааны дотор Цорос овгийн олон ноёдыг хаан суух бий, надаас урвах нь гэсэн хий хардлага, бас түүний үр удам нь хаан суух бий хэмээн олон ноёдыг хороосон тухай мэдээлэл манжуудын цуглуулсан тагнуулын мэдээлэлд авагдсан байдаг. Даваач Зүүнгарын хаан ширээг эзэлсний дараа өөртэй нь хаан суурь булаалдах магадлал өндөр ноёдын удам угсааг устгасны дотор Цэвээнравданы дүү Данжин-Омбугийн ачийг хороожээ. Чин улсын их цэрэг Зүүнгарыг эзэлсний дараа Дөрвөн Ойрадад дөрвөн хан тавих асуудлыг хэлэлцэв. Энэ үеэр Цоросын ханаас Галсандоржийн тавих эсэх, Галданцэрэний хөвүүдийн үр удам үлдсэн эсэхийг тодруулах үүргийг Умард дахиныг тогтоогч жанжин Бандид даалгажээ. Тэрбээр тайлан мэдүүлэхдээ “Цэвээнравданы төрсөн дүү Данжин-Омбын хөвүүн эдний ойр төрөл учир Даваач нууцаар хүн илгээж алжээ. Үүний нэг хөвүүн сая дөрвөн нас”<sup>23</sup> гэжээ.

Манжууд Даваачийг Бээжин хотноо авчирсаны дараа түүнийг алж хороосонгүй, харин 11-р сарын харагчин хонь өдөр хошой чин ван өргөмжилж, Халуун голд суулгав. Тэрээр 1759 оны 7-р сарын 23-нд өвчнөөр нас барсанд, түүний ахмад хөвүүн Лувсанд зэрэг бууруулж төрийн жүн ван залгамжлуулав.

“Илтгэл шастир”-ын мэдээгээр түүний ахмад хөвүүн Лувсанд 1756 онд гүнгийн зэрэг шагнаад, 1759 онд төрийн жүн ван залгамжлуулжээ. 1763 онд хошууны гэгэд холбож хошууны эфү болгожээ. 1774 онд бичгийн эрхэлсэн сайд Шүхэдэ Лувсаныг зоргоор гадаад тушаалын түшмэдтэй ханилан ховдог авлигатай ашгийг хичээн явав хэмээн буруушаан айлтгасанд, зарлигаар жүн вангаас буулгаж, хэргэмийг эвджээ<sup>24</sup>. Түүний дараа Даваачийн хоёрдугаар хөвүүн Бүтэх-д 1774 онд зэрэг бууруулж төрийн бэйл залгаад 1781 онд сул тушаалд хичээн зүтгэхгүй учир зарлигаар тушаалаас буулгажээ. Түүний дараа Лувсангийн ахмад хөвүүн Фурна-д 1781 онд зэрэг бууруулж хошууны бэйс залгуулаад, дараагаар 1783 онд зарлигаар бэйсийн хэргэмийг үе улиран тасралтгүй залгамжлуулав. 1797 онд нас баржээ.

Түүний дараа Фурнагийн хоёрдугаар хөвүүн Гэнгинсуд 1797 онд хошууны бэйс залгуулжээ. 1838 онд нас баржээ. Түүний дараа Гэнгинсугийн хөвүүн Ихэнгэд хошууны бэйс залгуулж, 1854 онд дэд зэрэг хиа тавив<sup>25</sup>.

<sup>22</sup> Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг, өмнөд зохиолын “Хааны бичсэн Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичгийн оршил. //Bibliotheca oiratica – LXXXIX (89). УБ., 2020:17

<sup>23</sup> 1755 оны 6-р сарын 17-ны өдөр, Умард дахиныг тогтоогч жанжин Бандийн айлтгал. //Зүүнгар улсыг мөхөөсөн, хүн амыг хядсан тухай манж сайдуудын айлтгал – I. Манжаас орчуулсан Л.Энхсаруул. Bibliotheca oiratica-СХХVII (127). УБ., 2024:114-116

<sup>24</sup> “Илтгэл шастир”, дэвтэр 94. Цоросын хошой чин ван Даваачийн олдворын шастир. //Bibliotheca oiratica – XCIX (99). УБ., 2020:153

<sup>25</sup> “Зарлигаар тогтоосон залгаж зохиосон Гадаад мужийн монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн

## ДҮГНЭЛТ

Даваач нь Зүүнгар улсын их тайж болох Их Цэрэндондовын ач хөвүүн, өвөг эцгийнхээ харьяат ардыг өвлөсөн ихээхэн эрх мэдэлтэй тайж байв. Түүнийг “хүн захирч чадах хүн” гэж Галданцэрэн хаан үнэлж байснаас гадна дараагийн хаан ширээнд суусан Цэвээндоржнамжил, Лхамдаржаа нар түүнтэй “болгоомжтой” харьцдаг байжээ.

Даваач Хойдын ноён Амарсанаатай холбоолж Лхамдаржаагаас Зүүнгарын хаан ширээг булаан авч билгийн улирлын өвлийн сүүл сарын 14 буюу 1753 оны 1-р сард Зүүнгарын хаан ширээнд суужээ. Даваач 1753-1755 онд 2 жил гаруй Зүүнгарын хаан ширээнд суусан, Зүүнгар улсын сүүлчийн хаан юм.

Даваачийг хаан ширээнд суухыг Цорос угсааны тайж нар эсэргүүцэж эхэлжээ. Түүний 2 жилийн засаглал амар тайван, гадаад дотоод бодлогоо бэхжүүлэх боломж олгосонгүй, үргэлжийн дотоодын дайн самуун үргэлжилсээр байв.

- 1753 оны зун Цоросын Нэмэхжаргалын бослого,
- 1753 оны намар Нэмэхжаргалыг дэмжсэн Дөрвөдийн тайж нар 3000 гаруй эрх хүн амаа дагуулан Манж Чин улсад дагаар оров.
- 1753 оны намар Цэвээнравданы зээ нар болох Хойдын Данжинванбугийн дөрвөн хөвүүн Абгэлэг, Абраг, Эсгэх, Чойдаш нарын бослого,
- 1753 оны билгийн улирлын өвлийн сүүл сараас 1754 оны 8-р сар хүртэлх Хойдын Амарсанаа Хасагийн дэмжлэгтэйгээр Даваачийг довтолж, эсэргүүцэн байлдсан дотоодын дайн,
- 1754 оны өвлийн туршид явагдсан Хойдын Бадамцэрэн болон Хасагийн довтолгоон.

Үүнээс Амарсанаатай хийсэн харагчин тахиа (1753) жилийн оны өвлийн сүүл сар буюу 1754 оны 1-р сараас Хөх нохой жилийн намрын эхэн сар буюу 1754 оны 8-р сар хүртэл 7 сар өрнөсөн Даваач-Амарсанаа нарын тэмцэл тэмцэл Зүүнгар улсыг туйлдуулан хоосруулсан хортой үр дагавар дагуулжээ. Эцэст нь Амарсанаа, Нэмэх нарын 4000 өрхийн 20000 гаруй ам хүн Манжид дагаар оржээ.

Даваач хаан цагийн байдалд тохируулсан гадаад дотоод бодлого явуулж чадсангүй, түүнд дотоодын эсэргүүцэгч нар боломж олгосонгүй. Эцэст нь Дундад болон Төв азийн улс төрийн гол тоглогч Зүүнгар улсыг Манжид эзлэгдэх нөхцөл бүрдсэн юм.

## Abstract

By examining the origins of Dawachi, the sixth khan of the Dzungar Khanate, the circumstances of his accession to the throne, and the domestic and foreign policies he pursued, this study investigates a particular phase in the political and social

---

илтгэл шастир” (Илтгэл 7-12; Шастир 7-12). //Bibliotheca oiratica – С (100). УБ., 2020:49. Дэвтэр 10. Цоросын хошой чин ван Даваачийн олдворын шастир.

development of the Dzungar Khanate. In recent years, the incorporation of Manchu-language sources into scholarly research has opened new opportunities for further study and academic discussion on this subject. Dawachi was the grandson of Ikh Tserendondov, a leading taiji of the Dzungar Khanate, and himself a powerful noble who inherited his grandfather's subjects and considerable authority. Galdan Tseren Khan regarded him as "a man capable of ruling people," and the subsequent khans, Tseveen Dorjnamjil and Lkhamdarjaa, likewise treated him with caution. By forming an alliance with the Khoid noble Amarsanaa, Dawachi seized the Dzungar throne from Lkhamdarjaa and ascended as khan on the 14th day of the last winter month of the lunar calendar, corresponding to January 1753. Dawachi ruled the Dzungar Khanate for slightly more than two years (1753-1755) and was its final khan. Dawachi's accession was opposed by taiji nobles of the Choros lineage. Throughout his brief reign, he was never granted the stability necessary to consolidate his domestic or foreign policies, as continuous internal conflicts and unrest persisted within the khanate.

Major disturbances during this period included:

- the uprising of Nemekhjargal of the Choros in the summer of 1753;
- in the autumn of 1753, more than 3,000 households led by Dörvöd taiji nobles supporting Nemekhjargal crossing over and submitting to the Qing dynasty;
- the autumn 1753 rebellion of Abgeleg, Abrug, Esgekh, and Choidas, the four sons of Danjinvanbug of the Khoid lineage and grandsons of Tseveenravdan;
- the internal war from the last month of winter 1753 to August 1754, during which Amarsanaa, supported by Kazakh forces, launched repeated attacks against Dawachi;
- the incursions during the winter of 1754 by Khoid Badamtseren and Kazakh forces.

Among these conflicts, the seven-month struggle between Dawachi and Amarsanaa - from the last winter month of the Year of the Black Rooster (January 1754) to the early autumn of the Year of the Blue Dog (August 1754) had particularly devastating consequences, exhausting and impoverishing the Dzungar Khanate. Ultimately, Amarsanaa, Nemekhjargal, and more than 20,000 people from approximately 4,000 households crossed the Qing border and submitted to Qing rule.

Dawachi failed to pursue domestic and foreign policies suited to the political realities of his time, largely because persistent internal opposition deprived him of the opportunity to do so. As a result, the conditions were created for the Dzungar Khanate, once a major political power in Central Asia, to fall under Qing conquest.